

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар А/77

Улаанбаатар хот

ГЭРЭЭ, МАЯГТЫН ЗАГВАР БАТЛАХ ТУХАЙ

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.10 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

- 1.Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангахад хамтран ажиллах гэрээ"-ний загварыг нэгдүгээр, "Гэрч, хохирогчийг нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник, хэрэгслээр хангах хамгаалалтын арга хэмжээний гэрээ"-ний загварыг хоёрдугаар, "Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулахад хамтран ажиллах гэрээ"-ний загварыг гуравдугаар, "Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтад авах гэрээ"-ний загварыг дөрөвдүгээр, "Биечилсэн хамгаалалтын арга хэмжээний гэрээ"-ний загварыг тавдугаар, "Урьдчилан сануулах хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлсэн тухай тэмдэглэл /маягт 1/"-ийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 2.Энэ тушаалаар батлагдсан гэрээний загварыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Авлигатай тэмцэх газрын дарга /тэргүүн комиссар З.Дашдаваа/-д зөвлөж, Тагнуулын ерөнхий газрын дарга /хурандаа П.Одонбаатар/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа Ж.Болд/ нарт тус тус үүрэг болгосугай.
- 3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/-д даалгасугай.
- 4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 2015 оны А/88 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

САЙД Х.НЯМБААТАР